

# ТОЙМ

---



**ОЛОН УЛСЫН  
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2024.09.016

*Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв*

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- АНУ-ын 8-р сарын инфляц 2.5% гарлаа
- Ипотекийн зээлийн хүү 6.29% болж буурлаа
- NVIDIA компанийн хиймэл оюун ухааны салбарын ирээдүйн талаар эерэг хүлээлтүүд үүсээд байна
- Хятадын хувьцааны ханш инфляцын үзүүлэлтүүд тааруу гарснаас болоод унажээ.
- 8-р сард Хятадын хэрэглээний үнийн индекс 0.6%-иар өслөө
- Хятадын худалдааны тэнцэл 91.02 тэрбум ам.долларт хүрээд байна.

2024 он 9-р сарын 16

Dow Jones	41,393.78
S&P 500	5,626.00
Nasdaq	17,683.98
DAX	18,699.40
FTSE 100	8,273.09
S&P/ASX 200	8,128.80
HANG SENG	17,342.00

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	0.72%	1.38%	1.81%	9.83%	19.57%	19.69%
S&P 500	0.54%	2.83%	1.29%	17.95%	26.42%	26.91%
Nasdaq	0.65%	4.73%	0.30%	17.80%	29.00%	17.55%

2024 оны 9 сарын 16-ны 11:00



Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	0.98%	1.39%	2.06%	11.63%	17.65%	20.72%
FTSE 100	0.39%	0.03%	-0.46%	6.98%	7.28%	18.80%

2024 оны 9 сарын 16-ны 11:00



Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	0.43%	1.83%	2.04%	7.15%	11.74%	9.86%
Hang Seng	-0.73%	0.20%	-1.14%	1.08%	-5.23%	-30.85%

2024 оны 9 сарын 16-ны 11:00





## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### S&P500 индексийн ханш өсөж, өмнөх долоо хоногийн уналтаа нөхлөө

S&P 500 индекс нь 2023 оны гуравдугаар сараас хойших хамгийн их уналтаа үзүүлсэн ч өмнөх долоо хоногт өсөлтийг үзүүллээ. Технологийн салбарын хувьцаанууд хүчтэй өсөлт үзүүлснээр өсөлтийн төрлийн хувьцаанууд нь үнэ цэний төрлийн хувьцаанаас илүү өндрөөр өсжээ. Тухайлбал, NVIDIA компанийн хиймэл оюун ухааны салбарын ирээдүйн талаар эерэг хүлээлтүүд үүсээд байгаа нь хувьцааны өсөлтөд томоохон дэмжлэг болжээ.

### Хэрэглээний үнийн индексийн өсөлт буурлаа

Өмнөх долоо хоногийн эдийн засгийн мэдээллүүдээс хамгийн чухал нь Хөдөлмөрийн яамнаас гаргасан инфляцын тайлан байв. Хүнс, эрчим хүчийг хассан суурь хэрэглээний инфляц наймдугаар сард 0.3%-иар өссөн нь хүлээлтээс илүү өндөр үзүүлэлт болж, хувьцааны ханш арилжааны эхний хэдэн цагт буурахад нөлөөлжээ буурсан байна. Мөн үндсэн инфляцын түвшин наймдугаар сард 2.5% болж өнгөрсөн сарын 2.9 хувиас буурч зорилтот 2%-д ойртоод байна.

### Үл хөдлөхийн салбарт эерэг дохио харагдаж байна.

Ипотекийн зээлийн хүү 2023 оны хоёрдугаар сараас хойших хамгийн бага түвшинд буюу 6.29% болж буурсан ба энэ нь жилийн өмнөх 7.21%-иас бага байна. Үүнтэй зэрэгцэн орон сууцны зээлийн хүсэлтийн индекс өсөж, орон сууцны худалдан авалтын эрэлтийг нэмэгдүүлжээ.

### ХНС-ийн бодлогын хүүгийн шийдвэр хүлээлтэд байна.

9-р сарын 17-18-нд хүүг бууруулах шийдвэр гарах бөгөөд эдийн засагчид хүүг 0.25%-аар бууруулах магадлалтай гэж үзэж байсан бол, өнгөрсөн долоо хоногийн эцэст 0.50%-ийн бууралт хийх магадлалтай гэж таамаглах болсон байна.

### График 1: АНУ-ын S&P500 индексийн ханшийн таамаглал







## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

**Хятадын хувьцааны зах зээлд уналт үргэлжилж байна.**

Хятадын хувьцааны ханш инфляцын үзүүлэлтүүд тааруу гарснаас болоод унажээ. Энэ нь эдийн засаг нь удааширч, үнэ болон цалин буурах эрсдэл үүсч байгаатай холбоотой гэж шинжээчид үзэж байна. Үүний улмаас Шанхайн индекс болон CSI 300 индекс 2.23%-иар буурсан бол Хонг Конгийн Hang Seng индекс 0.43%-иар унасан байна.

### Хэрэглээний үнийн индекс өслөө

Наймдугаар сард Хятадын хэрэглээний үнийн индекс 0.6%-иар өссөн нь өмнөх сарын 0.5%-аас арай дээр үзүүлэлт боловч эдийн засагчдын таамагласнаас бага байв. Үндсэн инфляц, буюу хоол хүнс, эрчим хүчний үнийг хасаж гаргасан үзүүлэлт, 0.3%-иар өссөн нь долоодугаар сарын 0.4%-аас буурсан үзүүлэлт болжээ. Харин үйлдвэрлэлийн үнийн индекс жилийн өмнөхөөс 1.8%-иар унасан нь эдийн засгийн таамаглалаас муу гарсан байна. Инфляц бууралттай байгаа нь Төвбанкных нь мөнгөний зөөлөн бодлоготой зөрчилдөж байгаа тул хувьцаанууд уналттай байна.

### Хятадын 8-р сарын гадаад худалдааны тэнцэл

Хятадын экспорт наймдугаар сард 8.7%-иар өссөн нь эдийн засагчдын хүлээлтээс давж, долоодугаар сарын 7%-ийн өсөлтөөс илүү өндөр гарчээ. Харин импорт харьцангуй бага, 0.5%-ийн өсөлттэй гарсан бөгөөд өмнөх сарын 7.2%-ийн өсөлтөөс огцом буурсан байна. Үүний үр дүнд Хятадын худалдааны тэнцэл 91.02 тэрбум ам.долларт хүрч, долоодугаар сарын 84.65 тэрбум ам.доллараас өссөн байна. Улс орнуудын экспортын хязгаарлалтаас урьтаж экспортын дүн өндөр өсөлттэй байж магадгүй гэсэн таамаглалыг шинжээчид дэвшүүлээд байна.

Экспортын өсөлт нь Хятадын эдийн засагт эерэг тал болж байгаа ч шинжээчид АНУ-ын эдийн засгийн удаашрал болон худалдааны маргаанаас үүдэн олон улсын эрэлт багасах болзошгүйг анхааруулж байна.

### График 2: Hang Seng индексийн ханшийн таамаглал

abligun published on TradingView.com, Sep 09, 2024 11:25 UTC+8

Hang Seng Index, 4H, HSI O17,261.89 H17,305.91 L17,088.28 C17,120.54 -323.76 (-1.86%)



### Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

## Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

[illegible]